

МОНГОЛЫН СОЦИОЛОГИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖИЛ (тойм эргэцүүлэл)

С.Дашдаваа
Философийн ухааны доктор (Ph.D)

Ямар ч шинжлэх ухааны сэтгэлгээний хөгжлийн тухай ярихын тулд арга зүйн хувьд баримтлах үндсэн зарчмууд байдаг. Эдгээрээс тухайн цаг үеийн нийгмийн ухааны "зовлон бэрхшээл", ерөнхий хандлагаас хамааран заримд нь илүү (суурь) ач холбогдол өгдөг билээ.

Миний бие Монголын социологийн сэтгэлгээний хөгжлийн асуудлыг тоймлон авч үзэх оролдлого хийхдээ дараах хэдэн үндсэн зарчмыг баримталсан. Үүнд: *нэгд, гарвал-түүхийн; хоёрт, детерминизмийн; гуравт, системийн; дөрөвт, үйл ажиллагааны; тавд, бие хүний* зэрэг зарчим хамаарч буй юм.

Сүүлийн хоёр зарчим нь нийгмийн мэдлэгийн аль ч салбарт **онцгой** хамааралтай. Ялангуяа шинэ мянган, шинэ зуун "Хүний зуун" болно хэмээн дэлхий нийтээрээ тунхаглаад байгаа нөхцөл байдалтай үнэнхүү дүйцнэ хэмээн үзэж байна. Эдгээрийн үндсэн дээр Монголын социологийн сэтгэлгээний хөгжлийг авч үзэхдээ социологийн сэтгэлгээ, социологийн шинжлэх ухаан, социологийн мэдлэг боловсрол, социологийн мэргэжил зэрэг нь хоорондоо нарийн уялдаа холбоотой бие биендээ нэвчсэн нийлмэл, цогц (систем) зүйл боловч эдгээрийг хооронд нь адилтган үзэж болохгүй гэсэн үзэл баримтлалыг иш үндэс болгож байгаагаар онцлон тэмдэглэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

Нийтлэлийнхээ гол санааг дараах байдлаар илэрхийлье. Үүнд:

- I. Монголд социологийн сэтгэлгээ олон зуун жилийн түүхтэй, харин шинэхэн үеийнх нь бидний хэвшмэл сэтгэлгээний үүднээс авч үзвэл 1921 он буюу Ардын хувьсгалаас эхлэлтэй хэмээн үзэж байгаа;
- II. Монголын социологийн сэтгэлгээ шинжлэх ухааны маягаар хэлбэржсэн нь 1960-70-аад оны үетэй давхцана. Энэ үеэс хойш монголын социологийн сэтгэлгээ шинжлэх ухааны маягаар хэлбэржин хөгжихдөө хэд хэдэн гол чиглэлээр явжээ хэмээн үзэж болно.

Үүнд: **Нэгд**, Нийгмийн дэвшил хөгжлийн талаархи социологийн үзэл баримтлал нь эхэн үедээ капиталист бус хөгжлийн үзэл баримтлал, номлолыг боловсруулж, тэдгээрийг нийгмийн шинжлэх ухаан, улс төрийн бодлогын хүрээнд эргэлтэнд оруулсан үеийн нөлөөн дор хөгжиж эхэлсэн. Энд нэрт эрдэмтэн академич С.Норовсамбуу², доктор, профессор Ц.Намсрай³ агсан, академич Н.Жагварал⁴, доктор Ц.Балхаажав⁵ зэрэг олон хүнийг онцгойлон хэлэх хэрэгтэй бизээ. **Хоёрт**, Монголын нийгмийн шинэ харилцааг (социалист) системлэг байдлаар нь авч үзэхийг зорьж байв. Чингэхдээ манай социологичид нийгмийн танин мэдэхүйн "**хүн - шинжлэх ухаан - техник - үйлдвэрлэл**" гэсэн загварыг голчлон баримталж байжээ.

Гуравт, 1970-аад оноос социологийн сэтгэлгээнд бие даасан чиглэл гарч ирсэн бөгөөд энэ нь монголын нийгмийн бүтцийн талаархи социологийн үзэл баримтлалыг боловсруулж, түүнийг

2 С.Норовсамбуу. академич. "Философско-социологические проблемы некапиталистического пути развития. Теория, методология и проблематика". М. 1973., Некоторые проблемы исторического опыта некапиталистический путь развития МНР и рабочий класс. УБ. 1981., Материалы научной конференции, посвященной 50-летию Монгольской народной революции. УБ., К вопросу об определении понятия некапиталистические пути развития. В.кн: Некоторые проблемы исторического опыта некапиталистического пути развития МНР. УБ. 1970. "Теория, методология, проблематики". Автореф.док.дисс. М. 1973.,

3 Ц.Намсрай. "Формирование и развитие надстройки социалистического общества в странах, миновавших капитализм". (на опыте МНР) Автореф докт.дисс. М. 1973.,

4 Н.Жагварал. академич. Основные направления аграрной политики МНРП.-в кн., "Социальные и политические проблемы развитого социализма". Прага.1978., Аратство и аратское хозяйства. УБ. 1974.,

5 Ц.Балхаажав. Характер и специфика классовых противоречий в процессе некапиталистического развития в МНР. Автореф канд дисс. М. 1970.,

социологийн тодорхой судалгаагаар гүнзгийрүүлэн шинжлэн судалж, дүгнэхийг зорьж эхэлсэн бөгөөд энэхүү чиглэл нь ч монголын социологийн шинжлэх ухааны төлөв байдлыг ихээхэн хэмжээгээр тодорхойлсон хэвээр байна.⁶ **Дөрөвт**, Өөр нэг гол чиглэл нь монголын хүн амын нөхөн үйлдвэрлэлийн шинж чанарын өөрчлөлтийн талаархи үзэл баримтлал, сэтгэлгээний хөгжил юм. Энэ асуудлыг манай социологичид макро төдийгүй микро түвшинд нарийвчлан судалж, социаль прогнозчиллол хийхийг оролдож байсныг энэ салбарын сэтгэлгээний түүхээс тод харж болно. (Р.Гүр, С.Гомбо гэх мэт)⁷ **Тавд**, 1970-аад оны үеэс социалист системийн бүх улс оронд дэлхийн хэмжээний объектив, субъектив хүчин зүйлийн нөлөөгөөр социалист аж төрөх ёсны асуудал нийгмийн бүх шинжлэх ухаан, түүний дунд социологийн шинжлэх ухааны нэг гол объект болон тэргүүн эгнээнд гарч ирсэн. Энэ чиглэлээр монголын социологийн сэтгэлгээ их сонирхолтой замаар хөгжиж байсан юм. **Зургаад**, Монголын нийгэм судлаачид, ялангуяа социологичдын анхаарлын төвд ямагт байж ирсэн нэг асуудал бол бие хүн, хүмүүжлийн (социалист, коммунист) талаархи үзэл баримтлал, сэтгэлгээний номлол байсан юм. Эдгээр асуудлаар буурьтай, сонирхолтой олон арван бүтээл гарч байв. **Долоод**, Монголын социологийн сэтгэлгээний хөгжлийн талаар ярихдаа монголын нийгэм судлаачид төдийгүй монголын ард түмний соёл боловсролд гарсан хувьсгалт өөрчлөлтийн талаархи асуудлыг хөндөхгүй орхиж болохгүй.

1990 оноос ардчилсан хувьсгал гэж их ярьж байгаа билээ. Харин Монголын ард түмний оюуны сэтгэлгээнд гарсан жинхэнэ хувьсгалт өөрчлөлтийн асуудал бүдгэрэн мартагдаж байгааг хэлэх хэрэгтэй. Энэ үйл явцыг "соёлын хувьсгал" гэж нэрлэж байсан юм. Энэ чиглэлээр жинтэй том бүтээлүүд туурвигдсан билээ. Академич Б.Балдоо⁸, Ш.Бира⁹, Б.Лигүү¹⁰, Б.Түдэв¹¹ зэрэг олон арван хүнийг нэрлэж болох билээ. **Наймд**, Монголын социологийн сэтгэлгээний хөгжил нь нийгэм улс төрийн болон философи сэтгэлгээний хөгжлийг социологийн үүднээс хэрхэн авч үзэж байсныг хөндөхгүйгээр бүрэн бүтэн төсөөлөлтэй болж чадахгүй гэдэгт миний бие урьд нь ч, одоо ч, цаашдаа ч итгэл төгс байх болно. Академич Ч.Жүгдэр¹² агсан, доктор Д.Дашжамц¹³, А.Лувсанцэрэн¹⁴, Т.Содномдаргиа¹⁵ зэрэг олон хүнийг нэрлэж болох билээ.

1980-аад оны төгсгөл үе гэхэд Монголын социологийн сэтгэлгээ нь онол, арга зүй, социологийн тодорхой салбарууд, социологийн тодорхой судалгаа, практик хэрэглээ гэсэн нарийн нийлмэл бүтэцтэй бүхэл бүтэн цогц систем болон төлөвшиж чадсан гэж үзэж болох юм.

Социологичдын хэлж дадсанаар социологийн шинжлэх ухааны дунд түвшний онолуудын сэтгэлгээ буюу бие даасан салбар социологиуд төлөвшиж хөгжиж эхэлсэн.

Энд нийгмийн бүтцийн, соёлын, ахуй, гэр бүл, чөлөөт цагийн, боловсролын, олон нийтийн санал бодлын, хөдөлмөрийн, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн, залуучуудын, шашны тэрчлэн социологийн судалгааны арга техник гэх мэтийг онцлон тэмдэглэж болох юм.

1990-ээд он хүртэлх социологийн сэтгэлгээ нь парадигмын хувьд марксист номлолд захирагдаж байсны зэрэгцээгээр функционализм, структурно-функционализм, системийн, үйл ажиллагааны хандлагаар агуулгаа баяжуулсаар ирсэн гэж хэлж болно.

6 Доктор Ц.Уртнасан, Ц.Дагвадаш, Х.Гүндсамбуу нарын олон арван бҮтээл гарсан.

7 Р.Гүр ХҮн ам зҮй болон гэр бҮлийн тайлангууд.

С.Гомбо Проблемы формирования и развития социологического образа жизни в МНР. (Хамтын бҮтээл)

8 Б.Балдоо. академич. Проблемы культурной революции при переходе к социализму в странах, не прошедших капиталистической стадии (на опыте культурной революции в МНР. Автореф канд дисс. М. 1959.,) Сборник научных статей. Институт истории МНРП. 1956, №3

9 Ш.Бира. Академич. Некоторые вопросы новой национальной культуры в МНР, 1956,

10 Б.ЛигҮҮ. Формирование и становление социалистической культуры в МНР. Материалы научной конференции, посвященной 50 летию Монгольской Народной Революции. 1972.,

11 Б.Түдэв. Из истории рабочего класса МНР., 1963., Рабочий класс в борьбе за завершение строительства социализма МНР. 1980.,

12 Ч.Жүгдэр. академич. Развитие общественно-политической и философской мысли Монголии на рубеже XIX-XX вв. 1972., Философские учение Агваанбалдана. 1979.,

13 Д.Дашжамц./доктор/ Распространения и утверждение идей марксизма-ленинизма в Монголии. (1917-1940). 1973., Прогрессивные традиции нравственного воспитания Монгольского народа. 1968.,

14 Г.Лувсанцэрэн. доктор. Философское учение Нагаржуны. 1979,

15 Т.Содномдаргиа. доктор. Философско-логические взгляды монгольского философа Агваандандара. 1978., Эволюция ламаизма в современной Монголии. автореф. канд. дисс. М. 1979.

Монголын социологийн сэтгэлгээний хөгжлийн 1990-ээд оноос хойшхи үеийг нухацтай судалж үзээгүй, тийм захиалга, хэрэгцээ гараагүй учраас тоймтой юм хэлэхэд ихээхэн бэрхшээлтэй байгаагаа хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Гэвч "Шинжээч-XXI" ГЭЗДС-ийн социологийн мэдээллийн санд сургуулийн багш, эрдэмтэд, оюутнуудын хуримтлуулж, цуглуулсан мэдээлэлд үндэслэн тоймлосон бодомж, таамаглалуудыг дэвшүүлж болох юм.

1990-ээд оноос хойш социологийн сэтгэлгээнд ноёлох болсон чиглэл нь олон ургальч үзэл (плюрализм) юм болов уу гэж үзэж болохоор санагддаг. Гэхдээ энэ үеийн социологийн сэтгэлгээ нь :

Нэгдүгээрт, уламжлалт парадигмыг орчин цагтай тохируулан хэрэглэх. Сайндаа тэдгээрийг барууны онол, арга зүй, практикийн хувьд ажиллах чадвар нь хамгийн сайн хэмээн үзэж буй парадигматай хослон хэрэглэх, өөрөөр хэлбэл бид сэтгэлгээгээ шинэчилсэн гэж үздэг хандлагаар;

Хоёрдугаарт, нийгмийн цоо шинэ нөхцөл байдал, хэв маягийн учир шалтгаан, агуулга, хэтийн төлөвийг шинэ бодит байдлаасаа ургуулан авч үзэж чадах парадигмыг шинээр боловсруулж, туршиж үзэх оролдлого хийх чиглэл;

Гуравдугаарт, социологийн онол, парадигма, судалгаа, хэрэгслийг улс төр, үзэл суртал, бизнесийн ашиг хонжоо олох хэрэгсэл болгон ашиглах хандлагаар явж байх шиг санагдана.

1990-ээд оноос хойш МУИС-ийн социологийн тэнхим, ФСЭХ, Удирдлагын академийн социологийн судалгааны төв, УИХ-ын судалгааны төв болон нийт 14 төвийн 80 орчим судалгааны агуулга, хэрэгслүүдийг дээрхи 3 ангиллаар болзвол байдлаар авч үзэхэд:

- I. Сонгодог социологийн парадигмуудын (марксист болон түүнийг модернизацид оруулсан Э.Дюркгеймийн гэх мэт, функционализм, структурно-функционализмын) хүрээнд хийгдсэн нь 15 гаруй хувь;
- II. Шинэ парадигмын эрэл хайгуулын хүрээнд хийгдсэн судалгаа нь 5 хүрэхгүй хувьтай;
- III. Улс төр, үзэл суртал, бизнесийн зорилгоор хийгдсэн нь 60 гаруй хувь;
- IV. Сонгодог болон шинэ парадигмыг хослуулах оролдлого 10 хүрэхгүй хувьтай байна. ;

Энд "Шинжээч - XXI" НЭЗДС, түүний судалгааны төвийг оролцуулаагүй болно.

Монголд социологийн тэнхим, салбар байгуулагдсаны болон социологийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 10 жилийн ойг тэмдэглэж өнгөрүүлээ. Гэтэл социологийн сэтгэлгээний хөгжлийг 10 жилээр хязгаарлаж болохгүйг би дээр илэрхийлсэн бодомж, дүгнэлт, үзэл баримтлалаараа хэлэх гэсэн юм. Шинжлэх ухааны түүх үнэн, зөв байх ёстой.

Монголд 1972 онд ФСЭХ, 1974 онд МУИС-ийн философийн тэнхимд Социологийн лаборатори байгуулагдан, "Социологийн тодорхой судалгаа арга техник" гэсэн доктор, профессор Н.Хавхын социологийн анхны сурах бичиг 1974 онд хэвлэгдэж байсан.

Нийгмийн социаль асуудлыг социологийн онол, парадигма, арга зүйн үүднээс судлах ажлууд хийгдэж байсан. Монгол дахь социологийн шинжлэх ухааны сэтгэлгээний хөгжлийн түүхийг аль нэг үзэл суртал, удирдлага, хувь хүмүүсийн ашиг сонирхол, үзэл бодолд үйлчлүүлэн тодорхойлж боломгүй мэт.

Монголын Социологийн сэтгэлгээний шинэхэн үеийн түүх өөрийн судлаачдаа хүлээсээр байна.